

**Бразилд бага насны хүүхдэд япон хэл зааж буй
өнөөгийн байдал, тулгамдсан асуудал**

Шихахара Томоё

1. Удиртгал

Бразилын япон хэлний боловсрол япон гаралтай цагаач иргэдийн хүүхдэд зориулсан япон сургуулиас эхлэлтэй. Япон гаралтай цагаач иргэн гэж японоос гадаад орнуудад шилжин суурьшиж тухайн улсын иргэншил, удаан оршин суух эрх авсан япон хүн, мөн тэдний үр хүүхдийг хэлнэ. Дэлхийн 2-р дайны дараа тэдгээр япон сургууль япон хэлний сургууль болж өөрчлөгдсөн тул Бразилд 6-12 насны япон хэл суралцагчдын тоо олон хэвээр байна. Бодитоор хийгдсэн судалгаа байхгүй хэдий ч нийт япон хэл суралцагчдын 3-ны 1 буюу ойролцоогоор 6000 орчим хэмээн таамаглаж буй. “Хичнээн жил япон хэл сурлаа ч үсэг уншихаас хэтрэхгүй байна”, “Бага насны хүүхдэд япон хэл заах арга сүүлийн 20, 30 жил огт өөрчлөгдсөнгүй” гэх мэтээр шүүмжилж байна. Уг өгүүлэлээр бага насны хүүхдэд япон хэл зааж буй өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судалж, тэдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулах болно.

2. Япон хэлний сургалтын түүхэн өөрчлөлт

Сасаки (1999, 2003), Морарэсү Мацүхара (2013), Мацүнага (2015) нарын судалгаанд үндэслэн “Бразилын бага насны хүүхдэд япон хэл зааж ирсэн түүхэн өөрчлөлт”-ийг дараах хүснэгтэнд нэгтгэлээ.

Хүснэгт 1 Бразилын бага насны хүүхдэд япон хэл зааж ирсэн түүхэн өөрчлөлт

Он	Сургалтын зорилго	Сургалтын гол агуулга	Холбогдох үйл явдал
1920-иод он	Төрөлх хэл	Японд хэрэглэгдэж байсан төрөлх хэлний сурах бичиг ашиглан, уран уншлага, үсэг голлосон сургалтыг явуулж байв.	1930-аад онд 600 орчим сургууль байсан.
1950-иад он	Залгамжлах хэл	Бага насны хүүхдүүдийн япон хэлний чадвар ерөнхийдөө сайн байсан учир төрөлх хэлний сурах бичиг ашигласан, уншлага, үсэг голлосон сургалт амжилттай явагдсан. Япон хэлний чадвар муу байсан хүүхдүүдэд Бразилд	1961 онд “Япон хэл” сурах бичиг Бразилд хэвлэгдэв. Уг сурах бичигт бразилын нийгмийн амдрал, түүнд хэрэглэгдэх үг хэллэг зэргийг тусгасан боловч

		хэвлэгдсэн сурах бичиг ашиглаж байсан. Япон хэлнээс гадна биеийн тамир, бийрийн бичлэг, үйлчлэх хөдөлмөр гэх мэт хичээл орж, хүмүүжилийг чухалчлан үзэж байлаа.	японы төрөлх хэлний сурах бичгийг хуулбарласан байв.
1970-аад он	Залгамжлах хэл	Япон гаралтай ч японоор ярьж чаддаггүй хүүхэд нэг ангид хамт сурах болсон. Гэвч сурах бичиг ашигласан уншлага, үсэг голлосон сургалтанд өөрчлөлт ороогүй. Японтой холбоотой үйл ажиллагаа өргөн цар хүрээтэй зохион байгуулагдаж байсан.	Өгүүлбэрийн загвар голлосон “Япон хэлний яриа” сурах бичиг (бага насныханд зориулсан) бразилд хэвлэгдсэн.
1990 ээд он	Залгамжлах хэл / гадаад хэл	Японоор ярьж чаддаггүй хүүхдийн тоо нэмэгдсэний улмаас сурах бичиг ашигласан уншлага, үсэг голлосон сургалт явуулах боломжгүй болсоныг сургуулийн удирдлага, багш нар хүлээн зөвшөөрч өгүүлбэрийн загвар голлосон сургалтыг явуулахаар болсон.	Бразилд амьдардаг японы цагаач бус япон хэл суралцагчдын тоо нэмэгдсэний улмаас цагаач иргэдийн япон хэлний сургууль дараах 3 төрөлд хуваагдсан. А. Насанд хүрэгчдийн Б. Хувийн сургууль
2000-аад он	Гадаад хэл	Өгүүлбэрийн загвар голлосон сургалт явуулсан ч ярих чадварыг нэмэгдүүлж чадаагүй бөгөөд япон гаралтай хүүхдүүд япон хэлнээс улам хөндийрсөөр байсан. Нөгөө талаас дуу, цаасан нугалбар гэх мэт соёлын танилцуулга голлосон хичээлийн цаг нэмэгдсэн.	В. Бага насныханд зориулсан сургалтыг хуучин хэвээр хадгалсан.

Энд хүснэгт 1-д гарсан “залгамжлах хэл” гэсэн ухагдахууны тодорхойлолт, нэмэлт тайлбар хийе. Эрдэмтэн Накажима (2003) эцэг эх, өвөө эмээгээсээ өвлөж авсан хэлийг “залгамжлах хэл”, өсөн торниж байгаа орчиндоо байнга хэрэглэж байгаа хэлийг “оршин сууж байгаа орны хэл (төрөлх хэл)” хэмээн тодорхойлоод цагаачлалын 2-р үеийнхний хувьд дээрх 2 ухагдахууныг ялган хэрэглэнэ. Харин цагаачлалын 3-р үеийнхний хувьд оршин сууж байгаа орны хэл голлох учраас залгамжлах хэлийг нөхөн сургах хөтөлбөр байхгүй тохиолдолд цагаачлалын 3 дах үе дээрээ залгамжлах хэл нь оршин сууж байгаа орны хэл (төрөлх хэл) болж өөрчлөгдөнө гэж үзжээ.

Бид бразил дах япон хэл суралцагчид 1-рт гэр бүлийн орчинд япон хэл хэрэглэгддэг болохоор өдөр тутмын харилцан ярианы чадвартай, тэрхүү чадвараа хадгалж үлдэхийн тулд, 2-рт гэр бүлийн орчинд хэрэглэж эзэмшсэн харилцан ярианы чадварт суурилан уншиж бичсэнээр хэлний болон сэтгэлгээний чадвараа хөгжүүлэхийн тулд, 3-рт бие хүний төлөвшил, өв соёлоо хадгалж үлдэхийн тулд “залгамжлах хэл болгож” япон хэл суралцаж байгаа хэмээн таамаглаж байна.

Мөн хүснэгт 1-ээс сургалтын зорилго нь төрөлх хэл, залгамжлах хэл, гадаад хэл болж өөрчлөгдсөн болохийг харах боломжтой. Эрдэмтэн Морарэсү Мацүхара (2013:99) дэлхийн 2-р дайны дараа япон хэлний сургууль дахин сэргэсэнээр хэл залгамжлагдсан мэт харагдаж байгаа ч энэ нь ташаа ойлголт бөгөөд 1970-аад онд цагаач иргэд гэртээ ч португал хэл хэрэглэж байсан гэж үзжээ. Тиймээс төрөлх хэл нь япон хэл бус суралцагчид “гадаад хэл” болгож япон хэл сурахад зориулсан өгүүлбэрийн загвар голлосон сурах бичиг шаардлагатай болсон.

1970-аад онд цагаач иргэд гэртээ португал хэлээр ярих болсон хийгээд 1990-ээд оноос цагаач бус япон хэл суралцагчдын тоо нэмэгдсэн зэргээс үл хамааран 2012 оны япон хэлний сургалт явуулж буй байгууллагын талаарх судалгаа (Япон сан 2013)-гаар япон хэлний сургалтын зорилгоо “төрөлх хэл, залгамжлах хэл” хэмээн хариулсан байгууллага 59.1% байна. Дээр өгүүлсэн “залгамжлах хэл” болгож япон хэлийг суралцах зорилго нь 1-ийн харилцан ярианы чадвараа хадгалах, 2-ийн хэлний болон сэтгэлгээний чадвараа хөгжүүлэхийн тулд бус харин 3-ийн бие хүн төлөвшихийн тулд байсан байна. Цагаач суралцагчдын хувьд төрөлх хэл нь португал хэл боллоо ч залгамжлах хэл болгож япон хэл суралцдаг гэж хэлж болно. Тэгвэл төрөлх хэл нь португал хэл болчихсон юм бол гадаад хэл болгож япон хэлийг заах аргазүй шаардлагатай болж байна. Энэхүү “залгамжлах хэл” болох япон хэл, “гадаад хэл” болох япон хэл гэсэн 2 тал нь сургалтын орчинд хэрхэн нөлөөлж байгааг авч үзье.

3. Боловсролын байгууллагын өнөөгийн байдал

1990-ээд онд цагаач иргэдийн япон хэлний сургууль 3 хэсэгт хуваагдсан тухай хүснэгт 1-д өгүүлсэн. Тэдгээрээс Б. Хувийн сургууль, В. Бага насныханд зориулсан сургалтыг хуучин хэвээр хадгалсан япон хэлний сургуулийн сургалтын өнөөгийн байдлыг авч үзье. Судлаач миний бие 2013 оны 8 сараас 2015 оны 6 сард Санпауло хотын 6 хувийн сургууль, 5 япон хэлний сургууль нийт 11 сургуулиар явж судалгаа хийсэн.

Эдгээр 11 сургууль нь бага насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт сайтай хэмээн үнэлэгддэг сургуулиуд байсан ба бразилийн цагаач иргэдийн сургуулиудийн сургалтын ерөнхий байдлыг харж болохуйц сургуулиуд байсан. Дээрх 11 сургуулиас хувийн сургуулийн суралцагчдын тал хувь нь, япон хэлний

сургуулийн суралцагчдын бараг 100% нь цагаач иргэн байв. Сургалтанд ашиглаж байгаа сурах бичигт тулгуурлаад хүснэгт 2-т 11 сургуулийн хичээлийг 3 хэв шинжид хувааж тулгамдаж байгаа асуудлыг нэгтгэхийг зорилоо. Мөн судалгаанд хамрагдсан 11 сургуулиар зогсохгүй бусад сургуулиудын хувьд ч 2015 оны байдлаар 1-р хэв шинжид хамаарах сургууль маш цөөн, 2, 3-р хэв шинжийг хослуулсан сургууль олон байна гэж үзлээ.

Хүснэгт 2 Сурах бичигт тулгуурласан хичээлийн агуулгын ангилал

Хичээлийн гол агуулга	Ажиглалт хийсэн суралцагчдын байдал
1-р хэв шинж Японы төрөлх хэлний сурах бичиг ашигласан сургалт:	
Тухайн суралцаж байгаа ангиас 2-3 анги доогуур төрөлх хэлний сурах бичиг ашиглаж, унших, сурах бичигт байгаа эхийг хуулж бичүүлэх хичээл голлон явагдаж байв. Мөн унших, сурах бичигт байгаа эхийг хуулж бичүүлэх хичээлийн дараа орчуулж утгыг ойлгох ганцаарчилсан үйл ажиллагаа давамгайлж байлаа.	<ul style="list-style-type: none"> • Багш япон хэл дээр шууд аргаар хичээлийг удирдан явуулж байсан болохоор амархан асуултанд толгой дохиж хариулахаас гадна дан үгийн түвшинд хариулж чадаж байсан. Мөн өгүүлбэрийн түвшинд уншиж, бичиж чадаж байв. • Чанга дуугаар уншиж чадаж байсан боловч сурах бичгийн агуулгатай холбоотой асуултанд бараг хариулж чадахгүй байсан.
2-р хэв шинж Өгүүлбэрийн загвар голлосон сурах бичиг ашигласан сургалт: “Хүүхдэд зориулсан япон хэл”, “Анхан шатны япон хэл”, “Япон хэлний үсрэлт” гэх мэт	
Товч тайлбар хийсний дараа сурах бичигт байгаа “Энэ Луисийн цүнх үү? Тийм / Үгүй” гэх мэт дүрмийн дасгалыг бичгээр хийх ганцаарчилсан үйл ажиллагаа давамгайлж байсан.	<ul style="list-style-type: none"> • Багш япон хэл дээр шууд аргаар хичээлийг удирдан явуулж байсан болохоор амархан асуултанд толгой дохиж хариулахаас гадна дан үгийн түвшинд хариулж чадаж байсан. Мөн өгүүлбэрийн түвшинд уншиж, бичиж чадаж байв. • Чанга дуугаар уншиж чадаж байсан боловч сурах бичгийн агуулгатай холбоотой асуултанд бараг хариулж чадахгүй байсан.
3-р хэв шинж Зурагт хэрэглэгдэхүүн, видео хэрэглэгдэхүүн ашигласан сургалт:	
Үсэг заахаас гадна дуу, бүжиг, цаасан нугалбар, тоглоом, камишибай (зураг үзүүлж тайлбар хийдэг жүжиг) гэх мэт соёлын танилцуулга голлож байсан.	Хөгжилтэйгээр хичээлд оролцож байсан. Япон хэлийг мэндчилгээ, үгийн сангийн түвшинд эзэмшиж байв.

4. Тулгамдаж буй асуудал

4.1 Хэл шинжлэлийн үүднээс тулгамдаж буй асуудал

Эдгээр 3 хэв шинжид нийтлэг үсэг заах сургалт голлож байв. Судалгаанд хамрагдсан 11 сургууль хирагана, катакана, ханз үсэг заахад хичээлийн ихэнхи цагаа зарцуулж, утга ойлгохыг нэн тэргүүнд тавин эх хуулж бичих, товч тайлбар хийсний дараа өгүүлбэрийн загвар дээр ажиллах дасгалыг бичгээр явуулж байв. Гэвч утга дамжих харилцан яриа яриулах, утга дамжих эх уншиж бичих гэх мэт харилцааны чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа бараг байгаагүй.

Дээр дурдсан заах арга нийтлэг ажиглагдаж байгааг япон хүнд япон хэл зааж байгаа бичиг үсэгт таниулах сургалтын аргыг хуулбарласнаас үүдэлтэй хэмээн үзэж байна. Япон хэлийг төрөлх хэл болгон суралцдаг 6 настай хүүхэд 2000 гаруй үгийг хэрэглэж чаддаг, 5000 гаруй үгийг ойлгож чаддаг хэмээн үздэг (Ален Тамаи 2010:207). Өөрөөр хэлбэл тухайн авиаг сонсоод ихэнхи үгийн утгыг ойлгоно. Тэрхүү мэдлэгтээ тулгуурлан сургуульд орсоны дараа авиа ба үсгээ холбож ойлгох бичиг үсэгт таниулах сургалт, дуу гаргаж унших сургалт, ханзны сургалт явагдаж хэлний болон сэтгэлгээний чадварыг хөгжүүлнэ. 1970-аад оныг хүртэл үр дүнтэй хэмээн үзэж байсан боловч 1990-ээд онд янз бүрийн суралцагчид сурах болсонтой холбогдуулан өгүүлбэрийн загвар голлосон заах аргыг нэвтрүүлэх шаардлагатай болсон. Энэ заах арга нь харилцан ярианы чадварыг нэмэгдүүлэхийн тулд гарч ирсэн. Гэвч гол цөм болох дүрмийн хэлбэр эзэмшүүлэх дасгал, өгөгдөл бүхий аман дасгал нь насанд хүрэгчидэд үр дүнтэй хэдий ч бага насны суралцагчдад үр дүн багатай санагдсан. 3 дах хэв шинжид япон орон, япон хэлийг сонирхох сонирхол аажим аажимаар бий болж байгаа ч, 9, 10 нас хүрээд ирэхээрээ өгүүлбэрийн загвар голлосон сургалтанд шилжиж байгаа тул сурах хүсэл эрмэлзлэлээ алдах хандлага ажиглагддаг гэнэ.

Хүснэгт 1-д дурдсанчилан 1970-аад онд гэр бүлийн хүрээн дэх япон хэлний хэрэглээ багассан, төрөлх хэлний сурах бичигийн оронд өгүүлбэрийн загвар голлосон сурах бичиг бразилд хэвлэгдсэн гэх мэтээр сургалтын орчны хувьд “гадаад хэл болох япон хэл” болж өөрчлөгдсөн. Гэвч япон хэлний заах аргазүй нь “Төрөлх хэл, залгамжлах хэл болгож япон хэл” зааж байсан үеийнхээс өөрчлөгдөхгүй үсэг заах сургалт голлож байсан. Сургалтын орчин өөрчлөгдөөд байхад заах аргазүй өөрчлөгдөхгүй байгаа нь дараах 2 шалтгаантай хэмээн үзэж байна. Нэгдүгээрт япон хэлний сургуулийн удирдлага, багш, эцэг эх гэх мэт холбогдох хүмүүс бага насныхны нөхцөл байдлыг ойлгохгүй япон хэл хэрэглэж байсан өөрсдийн үетэйгээ ижил хэмээн үзэж заах аргаа өөрчлөх шаардлагатай байгааг ухамсарлахгүй байгаа. Хоёрдугаарт үсэг заах аргазүйгээс өөр үр дүнтэй заах аргазүй одоогоор байхгүй хэмээн үзэж байна.

4.2 Соёл сурахад тулгамдаж буй асуудал

Япон хэлний сургууль, хувийн сургуульд япон хэлний сургалтаас гадна боловсон хүчин бэлтгэх, бие хүн төлөвшүүлэх зорилго дэвшүүлж, япон хэлний сургалтаар дамжуулан японы уламжлалт соёлоо өвлөх сэтгэлтэй болгох, бразил улсад хувь нэмэрээ оруулах боловсон хүчин бэлтгэх гэсэн уриалга гаргасан. Сургуулийн холбогдох хүмүүсийн ярианаас цагаачдын нийгмийг авч явах дараагийн үеийнхэндээ япон сэтгэлгээг өвлүүлэх чин хүсэлтэй байгаа нь ажиглагдсан. Япон сэтгэлгээ гэж аливаад хүндэтгэлтэй, хичээл зүтгэлтэй, үнэнч шудрага, эмх цэгцтэй, цаг баримталдаг, буулт хийдэг, бусдад анхаарал тавьдаг, бусдыг ойлгохыг эрмэлздэг гэх мэт жишээ татсан байв.

Дээр дурдсан япон сэтгэлгээг төлөвшүүлэхийн тулд сургуулиас мэндчилгээ, аливаа үйл ажиллагаа дууссаны дараах эмхлэгээ зэргийг чухалчилан авч үзэхийн зэрэгцээ спарткад, зуны сургалт, охидын баяр, ээжийн өдөр, аавын өдөр, ахмадын баярын уулзалт, сакурагийн баяр, якисобагийн баяр гэх мэт японтой холбоотой үйл ажиллагааг аль болох түлхүү явуулахыг эрмэлзэж байна. Ахмадын баярын уулзалтаар өндөр настай цагаач иргэдэд цэцгийн баглаа бэлэглэж, концерт тоглон хүндэтгэл үзүүлж цагаачдын нийгмийн эв нэгдэлд тодорхой үүрэг гүйцэтгэж байна. Эдгээр үйл ажиллагаа нь япон сэтгэлгээ бий болгоход хэрхэн нөлөөлөх талаар нотолгоо байхгүй боловч ийм орчинд өссөн хүүхэд үйл ажиллагаанд идэвхитэй туслах хандлага ажиглагдаж байна хэмээн хэлж буй багш ч байв.

Гэвч дээр дурдсан япон сэтгэлгээг чухалчилахад сөрөг тал бас бий. “Япон хүн цаг баримталдаг болохоор та нар ч цаг баримталцгаа” хэмээн хэлж байгаагийн ард японы нийгмийг хэт сайшааж эсрэгээрээ, бразилийн нийгмийг үл ойшоох аюултай. Япон ч бразилтай адилхан бэрхшээлтэй тулгарч, гамшигаас хамгаалах, хүүхэд цөөрч хүн амын тоо багасах, өндөр наслалт нэмэгдэх гэх мэт хүн төрөлхтөний нэгэн адил саад бэрхшээлийг даван туулахыг эрмэлзэж байгаа нийгэм хэмээн авч үзэж, тэдгээр оролдлогоос харилцан хамтарч сурах хандлагыг төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

5. Асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Судлаач миний бие бага насны хүүхдэд япон хэл заахдаа үсэг голлосон аргазүй ч биш, өгүүлбэрийн загвар голлосон аргазүй ч биш зөвхөн насанд нь тохирсон, танин мэдэхүйн чадварт нийцсэн сургалтын аргыг хэрэглэх шаардлагатай гэж үзэж байна. Мөн соёлын үүднээс япон сэтгэлгээг өвлүүлэхийн тулд бус цагаач хүүхэд, японыг сонирхож байгаа бразил хүүхэд хамтдаа сурч соёлын ялгааг ойлгох чадвар эзэмшүүлэх аргыг эрэлхийлэх хэрэгтэй. Одоо тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Япон сангийн Санпауло дах японы соёлын төв (цаашид FJSP гэх)-өөс зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар танилцуулна.

5.1 Харилцааны чадварыг нэмэгдүүлэх

Харилцан ярианы чадварыг нэмэгдүүлэхийн тулд тухайн насны танин мэдэх чадварт тохирсон ангийн үйл ажиллагааг төлөвлөх, сургалтын үйл явцыг хянах, урт хугацааны сургалтын төлөвлөгөө боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Ангийн үйл ажиллагааг төлөвлөхдөө Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн онолыг ашиглах боломжтой. Ален Тамаи (2010:104) Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн онолд 7-12 насыг тодорхой үйлдлийн үе, түүнээс хойшхи үеийг хийсвэр үйлдлийн үе хэмээн үзсэн учир хэл сурах аргад 7-12 насанд бодит амьдралд нийцсэн орчин нөхцөл, сэдвийг нэгж болгон авч дасгал, туршилтаар дамжуулан япон хэлийг нэгтгэн дүгнэх сургалтын аргаар заах шаардлагатай. Харин 13 наснаас хойш дүрэм, өгүүлбэрийн загварыг хувиргах хийсвэр үйлдлийг хослуулсан ангийн үйл ажиллагааг төлөвлөх нь зүйтэй гэж үзжээ.

Сургалтын үйл явцыг хянахад гадаад хэл эзэмшихүйн судалгааг ашиглая. Гадаад хэл эзэмшихүйн судалгаанд хэл эзэмшихүй гэдгийг тогтоосон хэллэг, өгүүлбэрээ тэр хэвээр нь ашигласан тогтсон хэлбэр бүхий яриагаар эхлэж, аажим аажимаар түүний дотоод бүтцийг ойлгож хэл зүйн хувьд зөв хувиргах боломжтой болдог гэж үздэг (Мацүмүра 2012:200). Хэл сурах чадварыг нэмэгдүүлэхэд “хүлээн авах (сонсох, унших) → ойлголтоо гүнзгийрүүлэх → мэдлэгээ нэгтгэх → илэрхийлэх (ярих, бичих)” гэсэн сургалтын үйл явц маш чухал (Жакет Сла 2013:4). Насанд хүрсэн суралцагчид ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд зорилгоо өөрчилж олон дахин сонсож, уншиж, бусад суралцагчидтай бодлоо хуваалцах байдлаар өөрийн илэрхийлэлээ хянаж чаддаг бол танин мэдэхүйн хөгжлийн шатандаа яваа бага насны хүүхэд ингэж чаддаггүй. Тиймээс багшийн үүрэг хариуцлага өндөр юм. Өөрөөр хэлбэл шинэ үг хэллэгийг хэрэглээтэй нь хүлээн авсаны дараа багштайгаа сайтар ярилцаж ойлголтоо гүнзгийрүүлсэний үндсэн дээр сурсан мэдлэгээ ашиглан илтгэх, карт бичих гэх мэтээр илэрхийлэх тийм сургалт явуулах шаардлагатай байна.

Урт хугацааны сургалтын төлөвлөгөө боловсруулах тухайд бага сургууль төгсөх үедээ А1, залгамжлах хэлний хувьд А2-ийн дунд түвшинд хүрсэн байх гэсэн CEFR-ийг жишээ татмаар байна (Сато 2012:9). Бразилийн энгийн сургуульд долоо хоногт 1-2 цаг, жилд 30-60 цаг, 6-12 нас хүртэл 6 жил япон хэл сурна гэж үзвэл зорилгоо JF япон хэлний боловсролын стандарт (цаашид JF стандарт гэх)-ын А1 түвшин гэж тодорхойлох боломжтой. А1 гэж тогтсон хэлбэр бүхий хэллэг ашиглаж зайлшгүй шаардлагатай маш хялбар харилцааг явуулах үе шат, А2 гэж арай ахисан түвшиний өдөр тутмын харилцааг явуулах үе шатыг хэлнэ. 6 жилийн туршид А1 түвшиний агуулгыг давтамжтайгаар сургахад ангийн үйл ажиллагааны олон янзын санаа, шинэлэг зүйл шаардлагатай. А2 түвшинд хүргэхийн тулд А1

түвшинд юу заах шаардлагатай болохыг сайтар судалж, төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

2015 оны байдлаар Санпауло хотын нэгэн япон хэлний боловсролын байгууллага дээр өгүүлсэн зүйлийг тусгасан бага насны хүүхдэд зориулсан хэрэглэгдэхүүн боловсруулж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагааг FJSP дэмжин туслаж байна. Энэ нь А1 түвшинг 4 ботид хувааж (А1.0, А1.1, А1.2, А1.3) сурах хэрэглэгдэхүүн бөгөөд одоогийн байдлаар А1.1 туршилтын сурах бичгийг хийж дуусаад 2016 онд хэвлэхээр төлөвлөж байна. А1.1 туршилтын сурах бичгийг 7, 8 настай хүүхдэд зориулж тогтсон хэлбэр бүхий үг хэллэг сурахаар боловсруулжээ.

5.2 Өөр соёлыг ойлгох чадварыг нэмэгдүүлэх

Уг өгүүлэлд JF стандартад соёлын ялгааг ойлгох чадварыг “Өөрт мэдээжийн мэт санагдаж байгаа үнэлэмжийг эргэн харж, өөр үнэлэмжтэй хүнтэй ярилцаж, хамтарч ажиллах чадвар” гэж заасан (Япон сан 2009:18). Соёлын ялгааг ойлгох чадварыг төлөвшүүлэхийн тулд FJSP-гээс зохион байгуулж буй сургалтыг танилцуулья. FJSP-гээс жил бүр улсын болон хувийн сургуулийн япон хэл сурч байгаа 13-18 насны суралцагч (ойролцоогоор 25 хүн)-ийг 4 өдрийн сургалтанд хамруулж байгаа (Шихахара нар : 2015). Хоол, хоолны боловсрол, амьдралын хэв маяг гэх мэт бодит амьдралыг тусгасан орчин нөхцөл, эх ашиглаж үйл ажиллагаа, туршилтанд оролцсоноо нэгтгэн дүгнэж япон хэл сургахын зэрэгцээ соёлын ялгааг ойлгох чадварыг нэмэгдүүлэхийг зорьж буй. “Цагаач иргэн болон өөрийн гарал үүсэл” сэдэвт ажлаар өөрийн өвөг эцэг, эмэг эх, эмээ өвөөгийн гарал үүслийг дэлхийн газрын зураг дээр зааж, гэрийнхээ хоол, хоорондоо ярьдаг хэлний талаар японоор мэдээлэл солилцоно. Эцэст нь цагаач иргэдийг онцгойлон авч үзэлгүй өөрийн болон бусдын гарал үүслийг адилхан хүндэтгэх ёстой талаар төрөлх хэл дээрээ ярилцана. Цаашид энэ сургалтанд багшлах дадлага нэмж, Санпауло хотын хувийн дунд сургуулийн 6-12 насныханд сайжруулан турших төлөвлөгөөтэй байгаа.

6. Дүгнэлт

Уг өгүүлэлээр бразилийн бага насны хүүхдэд япон хэл зааж байгаа сургуульд үсэг голлосон сургалт явагдаж байгаа бөгөөд харилцааны чадварыг хөгжүүлж чадахгүй байгаа, цаг баримтлах, аливаад хүндэтгэлтэй хандах гэх мэт япон сэтгэлгээг чухалчилсанаар японы нийгмийг хэт сайшааж эсрэгээрээ, бразилийн нийгмийг үл ойшоох байдлыг дэмжих аюултай гэсэн асуудлыг дэвшүүлээ. Мөн эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлж байгаа танин мэдэхүйн хөгжил, хэлний сургалт 2-ыг хамтад нь авч үзсэн сургалтын арга, цагаачдын үр удам, япон орныг сонирхдог бразил хүүхэд хамтдаа япон хэл сурдаг бразилын нөхцөлд тохирсон соёлын ялгааг ойлгох чадварыг нэмэгдүүлэхийн тулд хийгдэж байгаа ажлыг танилцууллаа. Түүнээс гадна бага насны хүүхдэд хичээл

заахдаа “чимээгүй болгох, анхаарлыг төвлөрүүлэх, тайвшруулах, хариуцлага ухамсарлах үйлдэл хийлгэх, хичээл - тоглоом хоёрын ялгааг ойлгуулах” гэх мэт анги удирдан зохион байгуулах ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Бразилは世界最大の[日系人](#)居住地であり、[1908年](#)（[明治](#)41年）以降の約100年間で13万人の日本人がブラジルに移住した。約160万人の日系人が住むといわれている（この数字は移民式典の講演のものであり、実数調査が行われたわけではない）。しかしながら、二十世紀末から在伯日本人・日系ブラジル人が大量に日本に永住帰国あるいは移住した。ブラジルにおける日系人は日本への流出、旧移民の死去、混血による希薄化などで減少の一途をたどり、[1970年代](#)に移民船による集団移民が終わったことを受けて日本国籍を有する一世は希少である。

他方、在日ブラジル人は[2000年代](#)中頃まで顕著に増加した。日本政府の発表では35万人とされている（この中には日本国籍を持つ者、移住後に日本国籍を取得した者は含まれない）。日系以外のブラジル人との結婚率も高く、4世の61%が混血である¹⁸¹。

なお[2008年](#)（[平成](#)20年）は、日本人移民100周年を記念し、[日本ブラジル交流年](#)と制定され、両国で様々な催しが行われた。[パラナ州ロンドリーナ市](#)の式典では[皇太子](#)を迎えて[組体操](#)が披露されたが、演技者のほとんどが非日系人であった。2008年秋の[リーマンショック](#)以降、日本国内の不況を受けて製造業の雇用が減ったことから毎月1万人程のブラジル人が減少し、2011年時点では既に多くがブラジルに戻ったが、2012年に入り、再び日本への移住希望者が増え始めた。

年表

- [1892年](#)：ブラジル政府が日本人移民の受け入れを表明
- [1895年](#)：日伯修好通商航海条約締結
- [1908年](#)：正式移民開始（「[笠戸丸](#)移民」）
- [1915年](#)：初の[日本人学校](#)「[大正小学校](#)」開設
- [1917年](#)：海外興業株式会社設立
- [1919年](#)：初の農業組合である日伯産業組合が設立
- [1929年](#)：ブラジル拓植組合設立
- [1938年](#)：ヴァルガス大統領が移民同化政策を開始
- [1941年](#)：日本人移民受け入れ停止
- [1942年](#)：日伯国交断絶
- [1945年](#)：[第二次世界大戦](#)においてブラジルが日本に宣戦布告
- [1951年](#)：日伯国交回復
- [1953年](#)：日本人移民受け入れ再開

- [1954年](#) : 日系ブラジル人 2世の田村幸重が連邦議員に就任
- [1969年](#) : 日系ブラジル人 2世の[安田良治](#) ([ポルトガル語版](#)) が商工大臣に就任
- [1973年](#) : 移民船による移民廃止
- [1980年](#) : サンパウロ市議会「日本人移民の日」を制定 ([6月18日](#))
- [1989年](#) : 日本の出入国管理法が改正、日系ブラジル人就労者の受け入れ開始
- [2008年](#) : 日本人移民 100周年 (日本ブラジル交流年)